

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 25-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2025-11-25

Өндөртолгой

Нийслэл, дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-11, 12 фонтоор бичиж, **2025 оны 12 дугаар сарын 02-ний “Мягмар” гарагт 12.00 цагт Засаг даргын Тамгын газрын холбогдох бодлогын хэлтэст албан бичгээр, Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүд 16.00 цагт** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Эрх зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн (ERP Н.Батцэнгэл)-д word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ирүүлэхдээ Нийслэлийн Хяналт-шинжилгээ үнэлгээний газраас ирүүлсэн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 2025 оны 44 дүгээр зөвлөмжийн дагуу дараах шаардлагыг ханган тайлагнаж ажиллана уу.

1. Хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах, үйл ажиллагааны явц бус гарц, үр дүнг тайлагнах.

2. Үүргийн биелэлтийг тогтоосон хугацаанд, нотлох баримтын хамт, бүрэн гүйцэд тайлагнах.

3. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага бус үндсэн буюу бодлого хэрэгжүүлэгч байгууллага нэгтгэн тайлагнах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
0		
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1.	2025 оны байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тооцох, үнэлэх ажлын зохион байгуулах	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, ААНБ
2.	2025 оны шилдэг байгууллага, ажилтан шалгаруулах ажлыг зохион байгуулах	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
3.	Өвөлжилт хүндэрч байгаатай холбогдуулан цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээллийг малчид, мал бүхий иргэдэд хүргэх	Онцгой байдлын хэлтэс, Хороод
4.	Томуугийн дэгдэлт ихсэж байгаатай холбогдуулан нийтийг хамарсан тэмцээн уралдааныг цуцлах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх	Нийгмийн хөгжлийн хэлтэс, Эрүүл мэндийн төв, Боловсролын байгууллагууд
5.	Хичээл сургалтын үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжсэн тохиолдолд хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажиллах	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэс, Боловсролын байгууллагууд, Хороод
6.	Дүүргийн Шинэ жилийн баярын бэлтгэл ажлын хүрээнд гадна гэрэлтүүлэг, чимэглэлийг 2025 оны 12 сарын 15-ны өдрийн дотор хийх дуусгах	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
7.	91 дүгээр сургуулийн дотуур байрны бүтэц, хүчин чадал, бусад тооцооллыг гарган танилцуулах	Засаг даргын орлогч, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс, 91 дүгээр сургууль
8.	Хүйтний улирал эхэлсэнтэй холбогдуулан дэд бүтцийн байгууллагууд цахилгааны гэмтэл гарсан тохиолдолд ус, дулаанаар хангах нөөц эх үүсвэрүүдийг бэлтгэх	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Илч-Орд ОНӨААТҮГ, УСАТ, Онцгой байдлын хэлтэс
9.	Эрүүл мэндийн төвийн нөөц эх үүсвэрийг	Дүүргийн менежер, Хотын стандарт,

	ашиглалтад оруулах	тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
10.	Ирэх оны татварын орлогыг хэрхэн бүрдүүлэх талаар үйл ажиллагааг нарийвчилсан боломжит хувилбаруудыг судлах	Засаг даргын орлогч, Санхүү төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэс
11.	Дүүргийн цахим шилжилтийн үнэлгээ хийгдэх ажлыг зохион байгуулах	Засаг даргын Тамгын газрын дарга, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
12.	2025 оны 12 сарын 02-ны өдөр байгуулах Санамж бичгийн төслийг бэлтгэх, арга хэмжээг зохион байгуулах	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

ХЯНАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ОТГОНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Н.БАТЦЭНГЭЛ